

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үнэлгээний зорилго: Аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2010 оны жилийн эцсийн байдлаар ямар түвшинд байгааг тодорхойлох.

Суурь мэдээлэл:

- а/ Аймгийн ЗДТГ-ын 2010 оны ажлын тайлан
- б/ Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 20 хэрэгжүүлэгч агентлагийн 2010 оны ажлын тайлан, мэдээллүүд.
- в/ Аймгийн эдийн засаг, нийгмийн 2010 оны статистикийн эмхтгэл
- г/Булган, Дэлүүн, Толбо сум, аймгийн Эрүүл мэндийн газар, ХХААЖДҮ-ийн газрын 2009, 2010 онд үйл ажиллагаанд хийсэн ХШҮ-ний тайлан.

Үнэлгээний асуулт: 2010 онд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд ямар өөрчлөлт гарсан бэ?

Аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт орон нутгийн эдийн засаг, нийгмийн үндсэн 7 салбар, чиглэлийн бодлогыг тодорхойлсон 221 зорилт дэвшүүлж, тэдгээрийг хэрэгжүүлэхээр 349 арга хэмжээ төлөвлөн ажиллажээ. Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд 2009-2010 онд удирдлага зохион байгуулалтын дараах арга хэмжээ авч ажилласан.

Үүнд:

- Сум, агентлаг, байгууллагуудын байнга хяналтандаа байлгаж, хариуцаж хийх ажлын хуваарь гаргаж хүргүүлсэн.
- Нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу хэрэгжүүлэх ажлыг сумдын Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгуулсан.
- Хөтөлбөрийг олон нийтэд сайтар сурталчлах, эхнээс нь эрчимтэй хэрэгжүүлэх, явц, үр дүнг сайжруулах зорилгоор сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга нар, албан байгууллагын дарга, эрхлэгч нарын сургалт семинарыг жил бүр тогтмол зохион байгуулж ирсэн.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар авч байгаа арга хэмжээ, явц, үр дүнгийн байдлыг тусгай хуваариар сум, агентлагт газар дээр нь танилцан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөж байсан.
- Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хөрөнгө санхүүгийн боломжид тулгуурлан хамтран ажиллахаар зарим салбарын яам, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төсөл, хөтөлбөрийн удирдлага, үйлдвэр, бизнес эрхлэгчидтэй хамтарсан

уулзалт, зөвөлгөөн, семинар сургалт зохион байгуулж тодорхой асуудлаар санал солилцож зөвшилцөн шийдвэрлэж байсан.

- Аймаг, орон нутгийн нөөц бололцоог түшиглэн зохион байгуулахад хүндрэлтэй зарим асуудлыг УИХ-ын гишүүд, Засгийн газар, зарим Яам, агентлагт танилцуулан дэмжлэг, туслалцаа авч ажилласан зэрэг болно.

Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд буюу 2010 онд аймаг байгуулагдсаны 70 жилийн ой тохиосон бөгөөд энэ түүхт ойн хүрээнд 70 бүтээлч ажил хийх зорилт дэвшүүлэн амжилттай биелүүлсэн нь Засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чухал алхам болжээ.

Дэвшүүлсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэхийн тулд нийгэм, эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн 20 орчим бодлого, хөтөлбөр, журам, удирдамж боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд Засгийн газар, УИХ-ын гишүүдийн дэмжлэг, сум, агентлагийн удирдлагууд, аймаг, сумын ИТХ, төлөөлөгчдийн идэвхтэй үйл ажиллагаа, бүтээлч санаачилга шийдвэрлэх ач холбогдолтой байлаа.

Тухайлбал:


- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймаг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх ажилд идэвхийлэн орсон.
- Сум бүр алс хэтийг харсан хөгжлийн хөтөлбөртэй болсон.
- Сум, агентлаг бүр бүтээлч ажлын жагсаалт гаргаж хэрэгжүүлдэг болсон.
- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр сүүлийн 2 жилд аж ахуйн нэгж, иргэдэд 1,4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.
- Баяннуур, Ногооннуур, Булган, Цэнгэл сумууд малын тэжээл, хадлан бэлтгэл, төмс хүнсний ногооны үйлдвэрлэлд дорвитой ахиц гаргасан.
- Сагсай, Толбо, Алтай сумууд хөдөө, орон нутагт тоосго, шохой, гар урлалын чиглэлээр жижиг үйлдвэрүүд байгуулж ажлын байрны тоог нэмэгдүүлсэн.

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтын ажилд зориулан улс, орон нутгийн төсвөөс болон Олон Улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн нэгжүүдээс 2009 онд 14 тэрбум, 2010 онд 16,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь урьд өмнө байгаагүй үзүүлэлт юм.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээний дүнд дээр дурдсан нийт төлөвлөсөн ажлын БИЕЛЭЛТ 93,1%-тай байна. Үүний дотор 68,8% буюу 240 нь бүрэн хэрэгжсэн, 30,1% буюу 105 нь амжилттай хэрэгжиж байгаа гэсэн тооцоо гарлаа.

Үүнийг графикаар харуулбал:

Өөрөөр хэлбэл, 2010 оны жилийн эцсийн байдлаар хөтөлбөрт заасан 349 арга хэмжээний биелэлт 93,1% байна. Үүний дотор 240 арга хэмжээ 100%, 67 арга хэмжээ 90%, 14 арга хэмжээ 70%, 12 арга хэмжээ 50%, 12 арга хэмжээ 30 хувьтай байна.

2009-2010 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний харьцаа

Ийнхүү хөтөлбөрийн зорилт, авах арга хэмжээг амжилттай хэрэгжүүлснээр бүрэн эрхийн 4 жилд хүрэх түвшин, үр дүнг 4x2 буюу үндсэн ажил үйлчилгээний цар хүрээ, авах арга хэмжээ, гол ажлын үр дүнг 2 дахин өсгөж, сум, байгууллага салбарууд жил бүр нэг буюу 4 шинэ дэвшилттэй томоохон ажил үйлчилгээ бий болгох нэмэлт зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэх боломж бүрдсэн байна.

Эрүүл мэндийн салбарт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх талаар

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилтоор эхний ээлжинд аймаг, сум, өрхийн эмнэлгийн ажлын нөхцөл, тоног төхөөрөмжийн хангамжийг эрс сайжруулах, эмч мэргэжилтнүүдийг чадваржуулахад чиглэсэн цогц арга хэмжээ авч байна. Тухайлбал эрүүл мэндийн салбарын хэмжээнд 2009 онд нийт дүнгээр 570,9 сая, 2010 онд өмнөх оныхоос 3 дахин их буюу 1,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүний үр дүнд Алтай, Баяннуур, Булган, Ногооннуур сумдад тус бүр 15-20 ортой хүн эмнэлгийн барилга шинээр баригдаж, төв, хөдөөгийн

эмнэлгүүдэд түргэн тусламжийн туулах чадвар сайтай 9 автомашин, 20 орчим багийн эмч нарт мотоцикл олгогджээ.

Түүнчлэн аймгийн нэгдсэн эмнэлэг эмчилгээ, оношлогоо, шинжилгээний орчин үеийн багаж төхөөрөмжөөр хангагдаж, ажил үйлчилгээний нөхцөл нь эрс сайжирсан байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, амаржих газар нь Улаанбаатар дахь Эх нялхасын эрдэм шинжилгээний төв, Улсын клиникийн III эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төвтэй **АЛСЫН ЗАЙНЫ ОНОШЛОГООНЫ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН** нь төвөөс алслагдсан манай аймгийн хувьд томоохон дэвшил боллоо. Үүний зэрэгцээ өрхийн болон сумдын эмнэлгүүдэд тоног төхөөрөмжийн дорвитой шинэчлэл хийгдэж байна.

Эдгээрийг нэгтгэн дүгнэж үзэхэд аймаг, сумын эмнэлэгүүд эмчилгээ үйлчилгээ явуулахад боломжтой байртай, түргэн тусламжийн автомашины хувьд бэрхшээлгүй, хөдөөгийн багийн эмч нар унаатай болж, эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх боломж бүрдсэн гэж хэлж болохоор байна.

Эрүүл мэндийн үйлчилгээнд орчин үеийн техник, технологи нэвтрэхийн хэрээр эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, чадавхийг дээшлүүлэх шаардлага тавигдсан байгаа юм. Энэ шаардлагын үүднээс 2009 онд төвлөрсөн болон бүсчилсэн сургалтанд 150 эмч, 2010 онд 126 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж, чадваржуулах арга хэмжээ авлаа. Энэхүү арга хэмжээг цаашид эрчимжуулэхийн тулд Норвегийн тусламжийн байгууллагын дэмжлэгтэйгээр эмч, эмнэлгийн ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх төсөл хэрэгжүүлэхээр эхлээд байна.

Түүнчлэн аймгийн хэмжээнд иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг чиглэсэн зорилготой, системтэй болгосон нь үр дүнгээ өгч эхэллээ. Хүн ардын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн үндэсний хэмжээний “Халдварт өвчинтэй тэмцэх”, “Халдварт бус өвчнөөс сэргийлэх”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” зэрэг нийт 10 хөтөлбөрийг нутгийн захиргааны байгууллагын хяналтанд байнга авч дэмжлэг үзүүлж байгаа нь энэ салбарт тавьсан зорилгыг биелүүлэхэд ихээхэн түлхэц болж байна.

Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа “Эрүүл мэндэд ээлтэй байгууллага, Засаг дарга” шалгаруулах болзол зарлан дүгнэдэг, сумын эмнэлгийн эрхлэгч, багийн бага эмч, эрүүл мэндийн газрын дарга нарын хооронд “Эх, нярайн эрүүл мэндийг хамгаалах” гурвалсан гэрээ байгуулсан зэрэг зохион байгуулалтын шинэлэг ажлууд нь төрийн захиргааны байгууллагын санаачлага, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ болж байна.

Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт сумдад нарийн мэргэжлийн эмч нарын багийг тодорхой хуваариар ажиллуулж, үзлэг, үйлчилгээ, сургалтыг хослуулж хийдэг уламжлал тогтсон нь иргэдийн хүсэн хүлээдэг үйлчилгээний нэг боллоо.

Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, үйлчилгээг сайжруулах талаар авсан цогц арга хэмжээний үр дүнд 2010 онд 0-1 насны нялхасын эндэгдэл өмнөх оныхоос 20.6 промилээр, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 8,9 промилээр, эхийн эндэгдэл 44,7 промилээр тус тус буурсны дээр сүрьеэ зэрэг халдварт өвчний гаралт багассан эерэг үзүүлэлт сүүлийн жилүүдэд анх удаа гарч байна

Энэ нь бүх асуудал шийдэгдсэн гэсэн үг биш юм. Наад зах нь тус аймагт халдварт шар зэрэг өвчний дэгдэлт улсын дундчаас доогуур боловч харьцангуй нэмэгдсэн байгаа. Иймд цаашид эрүүл мэндийн үйлчилгээг орчин үеийн стандартын шаардлагын түвшинд үе шаттайгаар хүргэх, хүн ардын эрүүл мэндийг хамгаалах ажлыг сайжруулах талаар бүх шатны Засаг захиргааны болон эрүүл мэндийн байгууллага, иргэдийн өөрсдийнх нь оролцоог нэгтгэсэн цогц арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Биеийн тамир, спортын талаар авах арга хэмжээг хүн амыг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх ажилтай нягт уялдуулахад байнга анхаарч биеийн тамир, спортын заал танхим, чийрэгжүүлэх төв, клубуудын үйл ажиллагааг дэмжихэд чиглүүллээ. Тайлангийн хугацаанд “Биеийн тамирын сургалтыг сайжруулах хөтөлбөр боловсруулж, 4 сургуульд шинээр спортын заал барьж, ерөнхий боловсролын нийт сургиулуудыг биеийн тамир спортын хэрэгслээр хангасан.

2010 онд манай аймгийн залуучууд тив, Олон улсын болон улсын чанартай тэмцээнүүдээс уулын авиралт, сур харваа, бокс, шатар зэрэг төрлөөр 19 алт, 18 мөнгө, 11 хүрэл медаль хүртэж, Олон улсын хэмжээний мастер 1, спортын мастер 5, дэд мастер 13 төрөн гарсан нь өнгөрсөн оныхоос хэд дахин олон байна.

Энэ онд 2,0 орчим тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй биеийн тамир спортын цогцолборыг ашиглалтанд хүлээн авч ойрын үед дотоод тоног төхөөрөмжийг нь суурилуулах гэж байна. Монгол улсын Ерөнхий сайд манай аймагт ажиллах үеэр энэ асуудлыг тавьж, тоног төхөөрөмж авахад зориулан 153,0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэсэн.

Боловсрол, соёлын салбарт дэвшүүлсэн зорилтын биелэлтийн талаар

Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасны дагуу боловсролын салбарт сургалтын орчин, нөхцлийг цаашид сайжруулах, багш нарын ур чадварыг дээшлүүлэх, хамран сургалтыг нэмэгдүүлж, завсардалтыг бууруулах замаар тус аймагт доогуур байгаа сургалтын чанар, ерөнхий шалгалтын дүнг ахиулах, улмаар хүүхэд залуучуудын боловсролын чанарт дэвшил гаргахад чиглэсэн тодорхой ажлуудыг зохион байгууллаа.

Боловсролын салбарт 2009 онд 600,0 сая, 2010 онд 540,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ. Үүний үр дүнд урьд өмнө нь ихээхэн дутагдалтай байсан ЕБС-иудын дотуур байрны хатуу, зөөлөн эдлэл, сурагчийн ширээ сандал, сургалтын техник хэрэгслийн хангалт эрс сайжран Өлгий, Сагсай сумдад тус бүр бага сургууль, Алтай, Буянт зэрэг сумдын 4 сургуулийн спортын

заалын байр шинээр баригдаж, Алтай, Сагсай, Алтанцөгц сум болон Шүвтэр, Улаанхадын сургуулиудад өргөтгөл, нэр бүхий 8 цэцэрлгийн засвар хийгдэж, Цэнгэл, Дэлүүн, Баяннуур сумын сургуулиудыг засварласнаар 2000 гаруй хүүхдийн суралцах, амьдрах орчин сайжирсан байна.

2010 онд 579 компьютер нийлүүлснээр ЕБС-ийн компьютерийн тоо мянга орчим болж, нийт сургуулийн 42% нь интернетийн сүлжээнд холбогдсон байна. Бас олон сургууль “Багшийн хөгжлийн танхим”-тай болж байгаа нь багш нарыг чадваржуулах нэг алхам болжээ.

Тайлангийн хугацаанд хийгдсэн бас нэг томоохон ажил бол Казах хүүхдийн боловсролыг дээшлүүлэх асуудлыг Засгийн газар тусгайлан авч үзэж шийдвэр гарган эхний ээлжинд тус аймагт казах сурганы сектор байгуулсан явдал юм.

Энэ онд олон жил яригдсан Өлгий сумын ахлах I сургуулийн 1500 хүүхдийн хичээлийн байрыг 2011 онд барих асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн. Мөн Өлгий сумын 6-р багт арабын орнуудын тусламжаар барьж байгаа сургууль, эмнэлгийн цогцолборын барилгын ажил дуусах шатандаа орж байна.

Хөтөлбөрт дэвшүүлсэн ЕБС-ийн багш нарыг чадваржуулах зорилтын хүрээнд өнгөрсөн оноос эхлэн багш нарын дунд сонгон шалгаруулалт явуулж, чансаагаар нь байр эзлүүлж багшлах боловсон хүчнийг шилж сонгох журам нэвтрүүлсний дээр нийт багш нарын 70 орчим хувийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулснаар мэргэжилтэй багш нарын хангалт 99,3 хувьд хүрсэн байна.

Боловсрол, соёлын байгууллагын чадавхийг дээшлүүлэх, багш, мэргэжлтнүүдийн ур чадварыг сайжруулах зорилгоор нийт ЕБС, соёлын төвүүдийн үйл ажиллагаанд иж бүрэн хяналт, шинжилгээ хийж, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг тогтмолжуулсны дээр энэ оны сүүлийн улиралд ЕБС-иудыг аттестатчиллаа. Шинэ оны эхээр энэхүү аттестатчиллын мөрөөр тодорхой ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Боловсролын салбарын ажлын үндсэн шалгуур үзүүлэлт болох ерөнхий шалгалтын дундаж оноо сүүлийн хоёр жилд 27,6 пунктээр өсч, улсын дундажийн 94%-д хүрсэн нь энэ салбарыг хөгжүүлэх талаар зохион байгуулсан ажлын үр дүн юм.

Мэргэжлийн боловсролын чанарыг дээшлүүлэх ажлын хүрээнд Өлгий хот дахь Багшийн коллежийн хичээлий байранд 200,0 орчим сая төгрөгийн их засвар хийж, 300,0 гаруй сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэн сургалтын орчинг сайжрууллаа. Түүнчлэн тус аймаг дахь МСҮТ-ийн дотуур байранд их засвар хийж, сургалтын төлөвлөгөөг нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэнд нийцүүлэн уян хатан болгосноор нэр хүнд нь дээшилж, элсэгчдийн тоо жил бүр нэмэгдэж байна.

Энэ салбарт ажлын ийм ахиц дэвшил байгаа боловч сургалтын орчныг сайжруулах, багш нарын ур чадвар, хариуцлага, сургалтын чанарыг

дээшлүүлэх талаар хийх ажил их байна. Ялангуяа БСШУЯамтай хамтран казах сургуулиудын сурах бичгийн чанар, хангалтын асуудлыг нэг мөр цэгцлэх дорвитой арга хэмжээ авах шаардлага байна.

Тайлангийн хугацаанд соёлын байгууллагуудын материаллаг баазыг сайжруулах, соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн ажлуудыг зохион байгууллаа. Тухайлбал, аймгийн ХДТ-т 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж үзэгчдийн сандлыг бүрэн, хөгжмийн зэмсэг, гэрэлтүүлгийн болон дуу авианы тоног төхөөрөмжийн зарим хэсгийг шинэчиллээ.

Сумдын соёлын төвүүдэд нийт дүнгээр 110 гаруй сая төгрөгийн засвар тохижолтын ажил хийж, 40,0 гаруй сая төгрөгийн техник аппаратур, хөгжмийн зэмсэг нийлүүлээ.

Номын сангийн фондыг 43,2 сая төгрөгийн номоор баяжуулж, олон жил яригдаж байгаа барилгыг нь 2011 онд барихаар эцэслэн шийдвэрлэсэн.

Урлаг, соёлын бодлогын хүрээнд дэмжлэг үзүүлснээр ХДТ-ын уран бүтээлчид хөдөөгийн сумд болон бусад аймаг хотуудаар явж аялан тоглолт хийдэг болсон. Мөн театр, соёлын төвүүдэд ардын язгуур урлагийн дугуйлан, сургалт зохион байгуулдаг уламжлалтай болж, манай ардын авьяастнууд гадаад дотоодын нэр хүндтэй уралдаан, тоглолтуудад амжилттай оролцож, өндрөөр үнэлэгдэж байна.

Цаашид урлаг, соёлын асуудлыг өргөн утгаар нь ойлгож, нийгмийн сэтгэл зүйд эерэг хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн цогц ажлуудыг зохион байгуулах шаардлага байна. Наад зах нь ХДТ-ын уран бүтээлчдийн бүрэлдэхүүнийг стандартын түвшинд хүргэж нэмэгдүүлэх, чадваржуулах, сумдын соёлын төвүүдийг жинхэнэ утгаар нь ажиллуулах зэрэг арга хэмжээ авах ёстой.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр хийж байгаа ажлын талаар

Төрийн нийгмийн хамгааллын бодлогыг орон нутагт зохион байгуулж хэрэгжүүлэхдээ юуны өмнө иргэдийг ажилтай, орлоготой болгох асуудлыг тэргүүн эгнээнд тавьж байгаа юм. Энэхүү цогц асуудлыг үе шаттай шийдвэрлэхийн тулд эхний ээлжинд иргэдийг зах зээлийн нөхцөлд бие дааж амьдрах арга ухаанд сургах, тэднийг мэргэжилтэй, боловсролтой болгоход чиглэсэн зарим практик алхамуудыг хийж байна. Тухайлбал, Тогтвортой амьжиргаа төслийн нэгж, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран иргэдийн дунд төмс, хүнсний ногоо тариалах, өрхийн болон фермерийн аж ахуй эрхлэх, МАА-н бүтээгдэхүүн боловсруулах зэрэг чиглэлээр богино хугацааны эрчимжсэн сургалт, сурталчилгаа хийдэг уламжлалтай боллоо.

Түүнчлэн өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэхэд туслах зорилгоор зах зээлийн харилцааны анхан шатны сургалтуудыг чиглэсэн зорилготойгоор хийж байна. Эдгээр сургалтуудын үр дүнд олон мянган хүн өрхийн үйлдвэрлэл эрхэлж, амьжиргаагаа авч явах чадамжтай болсон тооцоо

гарч байна. Үүний зэрэгцээ нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдвал зохих иргэдийн судалгааг сум, баг бүрээр нарийвчлан гаргаж, бүлэг, нөхөрлөл байгуулах санаачлагыг нь дэмжиж урамшуулах замаар ажил, амьжиргааны эх үүсвэртэй болгох арга хэмжээ авч байна.

Тайлангийн хугацаанд энэ чиглэлийн үйлчилгээнд 4,0 мянган иргэн хамрагдсан байна. Төрөөс үзүүлж байгаа халамжийн үйлчилгээ нь эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааг дэмжихэд нэн чухал үүрэг гүйцэтгэж байна. 2010 онд 12,2 тэрбум төгрөгийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь 2008 оныхоос даруй 4 дахин их байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилт ч жил бүр нэмэгдэж байна. 2010 онд энэ сангаас 328,1 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн нь 2008 оныхоос 75,7 хувиар их байна.

Ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд авсан арга хэмжээний үр дүнд 2009 онд 1539, 2010 онд 1620 ажлын байрыг шинээр бий болгосон.

Ахмад настан, эхчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж, холбогдох хуулийн хэрэгжилтийн байдалд бүх шатны Засаг дарга нар бүртгэлээр хяналт тавьж байна.

2010 онд Өлгий хотод ахмадын өргөө, Толбо суманд ахмадын чийрэгжүүлэлт, сувиллын клуб, Булган зэрэг суманд ахмадын танхим байгуулагдсан нь ахмад үеийнхний талархлыг хүлээж байна.

Цаашид хөдөлмөр, халамжийн үйлчилгээг нийгмийн эмзэг бүлэгт эзнийг нь олж хүргэх, иргэдийг асруулан тэтгүүлэх сэтгэлгээнээс ангижруулах, хамгийн гол нь ажлын байрны тоог нэмэгдүүлэх, бие дааж амьдрах арга ухаанд сургах замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах явдал бүх шатны Засаг даргын эрхэм зорилго байх ёстой.

Үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх зорилтын биелэлтийн талаар

Үйлдвэр дэд бүтцийг хөгжүүлэх талаар хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг ханган биелүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсэн. Энэ салбарт 2009 онд 11,7 тэрбум, 2010 онд 12,6 тэрбум төгрөгийн ажил хийгдлээ. Эдгээрээс томоохныг нь дурдахад Өлгий хотын дулаан хангамж болон цахилгааны шугам сүлжээний шинэчлэл бүрэн дуусч нийт дүнгээр хөдөөгийн 13 багийг цахилгааны эх үүсвэрт холбож, Ховдын Дуут-Өлгий Булганы чиглэлийн ЦДАШ-ын барилгын ажил дуусах шатанд байна. Мөн Сагсай, Улаанхус суманд томоохон бетон гүүр, Булган, Дэлүүн, Алтай сумдад модон гүүрүүд баригдлаа.

Баруун бүсэд томоохонд орох 11,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нисэх буудлын хатуу хучилттай зурвасын барилгын ажлын гүйцэтгэл 70%-д хүрч, 2011 оны 7 дугаар сард ашиглалтанд авах боломжтой болсны дээр Өлгий Цагааннуурын хатуу хучилттай автозамд 2009 онд 1,0 тэрбум, 2010 онд 6,0 тэрбум төгрөгийн ажил хийгдэж, ашиглалтанд авах хугацаа нашилж байна.

Баруун бүсийн автозамыг хөгжүүлэх төслийн хүрээнд Өлгий-Хашаатын чиглэлийн хатуу хучилттай автозамыг БНХАУ-ын 50,0 сая ам долларын хөнгөлөлттэй зээлээр 2011 оны эхний хагасаас эхлэн барихаар эцэслэн шийдвэрлэсэн байна.

Түүнчлэн Өлгий хотын доторхи автозамыг 1,5 тэрбум төгрөгөөр засварлаж шинэчиллээ. Ер нь аймгийн 70 жилийн ой угтсан ажлын хүрээнд зөвхөн Өлгий хотод 2,4 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт, засвар тохижилтын ажил хийсэн байна.

Дэд бүтцийн салбарын дотор холбоо, мэдээллийн технологийн чиглэл бусдаас илүү хурдацтай хөгжиж байна. Тус аймаг дахь үүрэн телефоны операторуудын гаргасан мэдээгээр гар утас хэрэглэгчдийн тоо 124,0 мянгад хүрсэн байна. Холбоо, мэдээллийн технологийн салбарыг бодлогоор дэмжсэний үр дүнд өндөр хурдны зурвасын сүлжээг 2011 онд байгуулах нарийвчилсан тооцоог гаргаж, нийт сумдад өндөр хурдны төхөөрөмж суурилуулж интернетэд холбох боломж бүрдлээ.

Үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд 2009 онд 763,0 сая, 2010 онд 648,9 сая буюу нийт 1,4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 198 иргэн, аж ахуйн нэгжид олгосноор эхний ээлжинд 51 жижиг үйлдвэр шинээр байгуулагдаж 321 ажлын байр нэмэгдсэн байна.

Үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх талаар энэ мэт хийж байгаа ажил, үр дүн байгаа боловч одоогийн шаардлага, хэрэгцээг хангахгүй байна. Цаашид үйлдвэрлэлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх замаар иргэдээ ажилтай, орлоготой болгох нь бүх шатны Засаг дарга, менежерүүдийн эрхэм үүрэг, тэдний ажлыг дүгнэх гол шалгуур үзүүлэлт хэвээр байх ёстой.

Хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого, зорилтын хэрэгжилтийн талаар

Хөдөө аж ахуйн салбарыг бүхэлд нь эрчимжүүлэх, мал сүргийг эрүүлжүүлэх, байгалийн гамшиг, эрсдлээс хамгаалахад гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж ирлээ. Хөдөө аж ахуйн салбарт 2009 онд 1,0 тэрбум, 2010 онд 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Үүний үр дүнд сүүлийн хоёр жилд Улаанхус, Булган, Цэнгэл, Сагсай сумдад 500,0 сая төгрөгийн өртөгтэй 7 услалтын систем шинээр баригдаж, Өлгийн их булангийн услалтын системд 100,0 сая төгрөгийн их засвар хийснээр усалгаатай талбайн хэмжээ 4,3 мянган га-д хүрч, газар тариалангийн эрчимжилтэнд ахиц гарлаа. Мөн хоёр жилд 190,0 орчим сая төгрөгийн өртөгтэй инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргаж бэлчээр усжуулах арга хэмжээ авагдлаа. Тайлангийн хугацаанд мал чингүй нутгийн зэрэсүргийг эрүүлжүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт ажил үйлчилгээг бүрэн хийж, гоц халдварт өвглэлээ хадгалж чадсан нь гол зүйл юм.

Тайлангийн хугацаанд аймгийн мал сүрэгт ангилалт явуулж шилмэл омгийн мал, цөм сүргийг бүртгэн баталгаажуулсны дээр өндөр ашиг шимтэй малын гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлэг хийх, төвийн бүсээс сүүний чиглэлийн

цэвэр үүлдрийн үхэр авчирж үржүүлэх зэрэг ажлыг эхэлсэн нь мал аж ахуйг эрчимжүүлэх ажлын үндэс суурь юм.

Аймгийн Засаг захиргааны байгууллага, нийт ар иргэдийн хүчин чармайлт, төр, Засгийн газар, гадаад, дотоодын түншүүдийн дэмжлэг туслалцааны ачаар малчдад 780,0 гаруй сая төгрөгийн тусламж үзүүлж, зуд гамшгийг хамгийн бага хохиролтойгоор даван туулсан аймгийн тоонд орлоо

Түүнчлэн улсын аудитын газраас хийсэн шалгалтаар тус аймаг улсын хэмжээнд зуд, гамшгийн үеэр малчдад зориулсан тусламжийн хөрөнгийг хамгийн үр дүнтэй, зөв зарцуулсан гурван аймгийн нэгээр шалгарсан байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн хувьд тариалсан талбай, хураасан ургацын хэмжээ жил бүр өсч, олон мянган хүн өрхийн газар тариалан эрхэлж суч байгаа нь томоохон дэвшил гэж үзэж байна. Үүний үр дүнд манай аймаг төмс, хүнсний ногооны хэрэгцээнийхээ үлэмж хэсгийг дотооддоо хангах боломж бүрдэж байна. Өнгөрсөн онд Баяннуурын алим улсын хэмжээнд хэрэглэгчдийн сонирхлыг татсан, зарим аж ахуйн нэгжүүд 6,0 мянга хүртэл чацарганы суулгац тарьж ургуулсан зэрэг нь жимс, жимсгэний үйлдвэрийг дэмжиж, хөгжүүлэх боломж бүрдсэнийг харуулж байна.

Малчид өнгөрсөн өвөл, хаврын цас зуд, байгалийн гамшгаас сургамж авч, хадлангийн талбайгаа хашиж хамгаалах, усалж тордон ургац нэмэгдүүлэх, бэлчээрээ зөв зохистой ашиглах талаар ихээхэн анхаардаг болж үр дүнд хүрч байна. Энэ онд тус аймаг 58,5 мянган тонн хадлан бэлтгэж, Засгийн газрын үнэлгээгээр өвлийн бэлтгэл сайн хангасан эхний ДӨРВӨН аймгийн тоонд багтаж чадсан байна.

Энэ оны сүүлчээр аймгийн ХАА-н салбарыг тогтвортой хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлуулсан. Энэ хөтөлбөрт аймгийн ХАА-н салбарын тулгамдсан зорилтууд, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, хийх ажлыг тодорхой тусгасан байгаа.

Иймд уг хөтөлбөрийг жил улирлын хуваартайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ёстой. Нөгөө талаар саяхан сумдын ЗДТГазарт мал эмнэлэг, үржлийн тасаг байгуулж ажлынх нь чиг үүргийг тогтоож өгсөн. Энэ алба орон нутагт төрийн ХАА-н талаарх бодлого, шийдвэрийг гардан зохион байгуулах жинхэнэ эзэд нь байх ёстой юм

Байгаль хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн талаар

Тайлангийн хугацаанд байгаль хамгаалах байгууллага, ажилтнуудыг чадваржуулах, ажиллах боломж, нөхцлийг сайжруулах, байгаль орчныг хамгаалахад ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авлаа. Байгаль орчныг хамгаалах салбарт 2009 онд 58,2 сая, 2010 онд 141,5 сая төгрөгийн хөрөнгө орууллаа. Сүүлийн хоёр жилд байгаль орчин, аялал жуулчлалын газрыг шинэ байртай, ус цаг уур, орчны шинжилгээний төвийг пуужин харвах суурь, газрын генератор зэрэг үүлэнд зориудаар нөлөөлж бороо

оруулах төхөөрөмжтэй болгож, ажилтнуудыг нь сургалтанд хамруулж, чадавхийг нь дээшлүүлээ.

Хамгийн ихээр цөлжиж байгаа төв суурин газрууд болон бэлчээр нутгийн судалгааг нарийвчлан гаргаж, Өлгий, Бугат сумын нутагт мод үржүүлгийн талбай байгуулан, 190 мянган ширхэг улиас, бургасны суургац үржүүлж, 140 га талбайг ойжуулах цэцэрлэгжүүлэх арга хэмжээ авлаа. Байгаль, ой модыг хамгаалахад иргэдийн оролцоо нэмэгдэж Алтай, Дэлүүн, Сагсай, Цэнгэл, Ногооннуур, Бугат сумдад сайн дурын байгаль хамгаалагч 35 нөхөрлөл байгуулагдсан байна.

Мөн байгаль хамгаалах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БОАЖЯамтай хамтран “Алтай соёны экологийн үнэт зүйлсийг ард иргэдийн оролцоотойгоор хамгаалах” төслийн нэгж, Монгол Алтайн болон Хөх сэрхийн нурууны Улсын тусгай хамгаалалттай газрын захиргааг техник хэрэгслээр хангаж, мэргэжлитнүүдийг нь сургалтанд хамруулж чадваржуулах арга хэмжээ авлаа.

Тус аймаг нь Монгол Алтайн нурууны ноён оргилуудтай, олон үндэстэн, ястны өвөрмөц соёл, зан заншилтай, археологийн олдвор, түүхийн дурсгалт газар олонтой зэрэг давуу талдаа түшиглэн гадаад дотоодын аялал жуулчлалыг өргөжүүлэх талаар тодорхой бодлого, чиглэлтэй ажиллаж байна.

Нутгийн захиргааны байгууллагаас байгалийн болон угсаатны зүйн чиглэлийн аялал жуулчлалыг дэмжих бодлого барьж байгаагийн үр дүнд Алтай таван богд, Цамбагарав, Хөх сэрхийн нурууны чиглэлд аялагчдын тоо жил бүр өсч байна. Түүнчлэн аймгийн ЗДТГазар, аялал жуулчлал эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй хамтран жил бүр бүргэдчдийн баяр тэмдэглэдэг уламжлалтай болсон нь гадаад дотоодын жуулчдын сонирхлыг ихээхэн татаж байна. Тухайлбал, 2009 онд энэ баярт 10 гаруй орны 200 гаруй жуулчин оролцсон бол 2010 онд 20 орчим орны 300 гаруй жуулчин иржээ. Аймгаас тавьсан удаа дараагийн асуудлын хариу гарч бүргэдээр ан хийх ёс заншил ЮНЕСКО-гийн соёлын өвд бүртгэгдсэн байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар тавьсан зорилтын биелэлтийн талаар

Тайлангийн хугацаанд бүх шатны төрийн захиргааны байгууллагын чадавхи, төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, төрийн албаны ил тод байдлыг хангахад чиглэсэн томоохон зорилтууд дэвшүүлж хэрэгжүүлэх арга хэмжээ авлаа. Сүүлийн хоёр жилд төрийн захиргааны албан хаагчдыг төвлөрсөн болон бүсчилсэн, орон нутгийн сургалтанд ээлж дараатай хамруулснаар сум, агентлагийн удирдах ажилтнууд 100%, гүйцэтгэх ажилтны дийлэнх нь аль нэг шатны сургалтанд оролцож, мэдлэг чадавхиа дээшлүүлсэн байна.

Түүнчлэн төрийн албаны зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хүнд суртал чирэглийг арилгахад онцлон анхаарч төрийн захиргааны

байгууллагуудын дотоод журам, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчлэх ажлыг хийж дуусгаад байна.

Төрийн нэрийн өмнөөс иргэдэд үйлчилдэг эрүүл мэнд, боловсрол, мэргэжлийн хяналт, хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, татварын хэлтэс зэрэг байгууллагуудын нээлттэй хаалганы өдрийг аймаг, сумын төвд зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, үйл ажиллагааныхаа утга учрыг иргэдэд танилцуулж, тэдний санал хүсэлтийг сонсч ажилдаа тусгадаг уламжлалтай боллоо.

2009 оноос эхлэн Засгийн газрын шийдвэрээр аймгийн ЗДТГазарт хяналт-шинжилгээ, үнэлгээний алба, томоохон байгууллага, агентлагуудад нэгж байгуулагдан хяналтын тогтолцоо бүрдэж, бүх шатны төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд болон төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, үр дүнгээ өгч байна.

Эрх зүйн сургалт, сурталчилгаа, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд ахиц дэвшил гарч, гэмт хэргийн тоо буурч байгаа нь хууль, хяналтын байгууллагын хүчин чармайлтын үр дүн гэж үзэж байна.

Санхүү, төрийн сангийн бодлогын хэрэгжилтийн талаар

Тайлангийн хугацаанд орон нутгийн төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлэх, төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг эрс сайжруулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлж ажиллалаа. 2010 онд үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөж, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажлын үр дүнд татвар төлөгчдийн тоо нэмэгдэж, орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлэх боломж бүрдлээ.

Энэ оны төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөө 0,6 сая төгрөгөөр буюу 0,1 хувиар, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 137,0 сая төгрөгөөр буюу 5,6 хувиар давж биелэгдсэн байна.

Санхүүгийн тайлангаас үзэхэд энэ онд нийт төсөвт байгууллагууд өр, зээлгүй гарах боломжтой байгаа нь манай санхүүгийн алба, менежерүүдийн ажлын гол үр дүн юм.

2009-2010 онд Булганаас бусад бүх сумдыг төрийн сангийн сүлжээнд холбосон нь төсвийн зарцуулалтанд өдөр тутам хяналт тавих бололцоотой боллоо.

2011 онд дараахь асуудалд онцлон анхаарахыг зөвлөмж болгож байна.

1. Төр засгийн бодлогын чанартай баримт бичгүүдийн утга агуулга, үзэл санааны дагуу аймаг орон нутгийг үйлдвэржүүлэх дэд хөтөлбөрийг ИТХ-ын хуралдаанд оруулж батлуулан түүнийг хэрэгжүүлэх ажлыг иргэнээ

ажилтай, орлоготой, эрүүл, боловсролтой болгох эрхэм зорилттой нягт уялдуулж зохион байгуулах.

2. Дээрх бодлого зорилтыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд сум, байгууллага бүр байгалийн баялагийг ашиглах, мах, ноос, ноолуур, сүү, цагаан идээ боловсруулах, малын тэжээл бэлтгэх, хүн амын ахуйн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр үйлдвэр үйлчилгээ бий болгоход онцлон анхаарах.
3. Асгатын мөнгөний орд, Толбын зэс, Ногооннуурын холимог металл, Булганы төмрийн ордуудыг ашиглах талаар зохион байгуулж, хөөцөлдөж байгаа ажлаа үргэлжлүүлж үр дүнд хүргэх

Өлгий-Цагааннуур, Өлгий-Хашаатын чиглэлийн хатуу хучилттай зам барих ажилд идэвхтэй дэмжлэг үзүүлэх.

4. Өлгий хотын Нисэх буудлын зурвас болон бусад бүтээн байгуулалтын ажлыг хугацаанд нь дуусгах.

5. Аймгийн хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах бодлогын хүрээнд мал аж ахуйг эрчимжүүлэх, мал сүргийг эрүүлжүүлэх ажлыг оновчтой зохион байгуулах, мал, мах экспортлох, усалгаатай газар тариалан ялангуяа өрхийн газар тариаланг бүх талаар дэмжих зэрэг цогц арга хэмжээ авах.

6. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд чанарын ахиц дэвшил гаргах, орчин үеийн техник технологи нэвтрүүлэх, хүний нөөцийн чадахи, хариуцлагыг дээшлүүлэх.

7. Төрийн албыг ил тод, цэвэр тунгалаг байлгахад онцлон анхаарч бүх шатны төрийн албан хаагчдын мэдлэг боловсрол, соёл, ёс зүйг эрс дээшлүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай, аливаа хүнд суртал чирэгдэлгүй хүргэх зэрэг 8 багц асуудлыг 2011 онд аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахдаа баримтлах гол зарчим болгох нь зүйтэй гэж үзнэ.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2009-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРӨӨС ХЭРЭГЖИЛТ нь УДААШИРЧ БАЙГАА БОЛОН
ТАСАЛДАЖ ЯВАА ЗААЛТУУД**

д/д	Заалтын дугаар	Хөтөлбөрийн заалтын агуулга	Шалтгаан, зохион байгуулж байгаа ажил
Нэг. Эрүүл мэндийн үйлчилгээ			
1	1.1.15	Дурангийн хагалгааны аппараттай болно	Хөрөнгийн эх үүсвэргүй, мэргэжилтэн бэлтгэгдээгүй
Хоёр. Боловсролын үйлчилгээ			
2	1.2.5 /5/	Улаанбайшинтад бага сургууль, Хөх хөтөлд дунд сургуулийн дотуур байр барина	Хөрөнгийн эх үүсвэр хүрэлцээгүй учир хойшлогдсон
3	1.2.21	Орос лицей сургууль байгуулна	Шууд харилцааны шугамаар асуудал боловсруулан хөөцөлдөж байна. Эхний ээлжинд “Дарын” сургуульд ОХУ-аас багш урин ажиллуулж байна
Гурав. Соёл урлагийн үйлчилгээ			
4	1.3.2. /2/	Аймгийн ХДТ-ын уран бүтээлчдийг үйлчилгээний автобустай болгоно	Хөрөнгийн эх үүсвэргүй хүлээгдэж байна
5	1.3.7 /1/	Цагааннуур тосгоны Соёлын төвд засвар хийж, Буянт суманд шинээр Соёлын төв барина	Хөрөнгийн эх үүсвэр олдохгүй байгаа
<u>Дөрөв. Дэд бүтцийг хөгжүүлэх, үйлдвэржүүлэх бодлого</u>			
6	2.1.31	Улсын хилийн Улаанхус сумын хэсэгт хамгаалалтын тор татах	Хөрөнгийн эх үүсвэргүйгээс хүлээгдэж байна
7	2.1.42.	Алтай сумын “Бор бургас” багийг жишиг баг болгоно	УИХ-ын гишүүдийн дэмжлэгээр хийхээр төлөвлөж хөөцөлдөж байна. Хугацаа хойшлогдсон
8	2.1.49	Өлгий-Өскемений чиглэлд том оврын автобус явуулах	ОХУ-ын холбогдох байгууллагууд зөвшөөрөл олгохгүй байна

9	2.1.52	Радиогийн мэдээлэл түгээх чадамжийг дээшлүүлэх	Засгийн газар болон ОУ-ын байгууллагад танилцуулж хөөцөлдөж байна. Эхний ээлжинд 4 с манд FM радио станц нээлтээ хийсэн
10	2.1.72	Даянгийн Улаан уул, Цагааннуурын Улаан байшинтын хооронд хатуу хучилттай авто зам барина	Монгол улс ОХУ, Казахстан улсын Засгийн газрын түвшинд яриа хэлэлцээний хэмжээнд байна
11	2.1.73	Өлгий-Өскемений чиглэлд хатуу хучилттай автозам барих	ОХУ-ын холбогдох байгууллагууд зөвшөөрөл олгохгүй байна
<u>Тав. Хөдөө аж ахуйн бодлого</u>			
12	2.2.4.3	Өсвөр насны мал бордох аж ахуй байгуулах	Тэжээлийн нөөцгүйгээс сонирхогч аж ахуйн нэгж, иргэд гараагүй байгаа
<u>Зургаа. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн бодлого</u>			
13	4.1.10	Улаанхус, Дэлүүн суманд Цагдаагийн тасаг байгуулах	Төсөв хүрэлцээгүйгээс шийдэгдээгүй
14	4.1.15	Архивын байрыг шинээр барих	Барилга барих газар олгож хөөцөлдөж байгаа боловч хөрөнгийн эх үүсвэргүйгээс шийдэгдээгүй байна
15	4.1.20	Өлгийд Казахстан улсын консулын алба байгуулах	Гадаад хаарилцааны яамаар дамжуулан асуудал тавьсан шийдэгдээгүй

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2008-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ДҮНГИЙН НЭГТГЭЛ**
/2009-2010 он/

№	Агуулга	Нийт арга хэмжээ тоо	Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжиж байгаа	Үүнээс						х/б	Нийт хувь
					90	70	50	30	10	0		
1	Эрүүл мэндийн бодлого	16	12	4	3	1						96.2%
2	Боловсрол	39	20	19	12	2	3	2				87.9%
3	Соёл урлаг, ШУ	17	9	7	2	3	1	1			1	85.6%
4	Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, хүн амын бодлого	27	24	3	1	2						97.4%
5	Үйлдвэржүүлэх бодлого/ БО, дэд бүтэц/	127	77	48	30	3	7	8			2	89.6%
6	Хөдөө аж ахуйн бодлого	35	28	6	4	2				1		94.2%
7	Санхүү, төрийн сангийн бодлого	38	33	5	5							98.6%
8	Төрийн байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн бодлого	50	37	13	10	1	1	1				95.0%
Нийт		349	240	105	67	14	12	12		1	3	93.1%

